

КОММУНИКАТИВ ҮЙЛДЛИЙН ОНОЛ

Түлхүүр үг: философийн байрыг сэлгээч, тайлбарлагч үүрэг, стратегийн үйлдэл, хэм хэмжээг зохицуулагч үйлдэл, коммуникатив үйлдэл, когнитивизм, универсализм, формализм, дискурсын ёс зүй, коммюнити.

Философи сэтгэлгээний том том аврагуудын алдар хүнд өнгөрсөн зууны сүүлчээр дараа дараалан унаж, бүдгэрсэн билээ. 1940 өөд онд Гегелийг Карл Поппер “нээлттэй нийгмийн дайсан” гэж илчлэн гаргав. Марксын хувьд ч ийм явдал давтагдсаар 1970-аад онд “шинэ” философчид түүнийг хуурамч багш хэмээн салан одсон бол наяд онд социализм нь нуран унав. Дараачаас нь энэ хувь заяа Кантыг бас дайран түүнийг хуурамч парадигмыг тарнидан амьдруулагч том нэр хүнд гэлцэх болжээ. Ерөнхийдөө эх газрын эдгээр агуу философчдын алдар хүнд бүдгэрэн нэр төр нь Гуссерль, Хайдеггер, Ницце, Гадамер, Хабермас нарт аажмаар шилжиж байна.

Философийг шинжлэх ухааны маягаар бүтээх нь алдаатай гэж Гуссерль үзээд түүний “натуралист байдлыг” шүүмжилсэн билээ. Энэ нь философийг “тусгал” гэж ойлгох, тэгснээрээ эмпирик объектуудыг ухамсрын цэвэр үйлдлийн доор “дэвсэж өгөх” явдалд оршиж байна гэж үзэж байлаа. Хайдеггер метафизикийн сүйрэн унаж байгаа шалтгаан бол ахуйн тухай асуудлыг мартсанд оршино гэж баталсан юм. Тэрээр сүүлийнхээ бүтээлүүдэд метафизикийг даван туулах биш харин түүнийг өөрийнхөөр нь байлгах хэрэгтэй гэж бичиж байлаа. Неопозитивизм үүнийг бүр өөрөөр үздэг. Тухайлбал, философийг Карнап утга учиргүй өгүүлбэрүүдийн цуглуулга, Шлийк ямар ч гэсэн шинжлэх ухаан биш, харин шүлэг найраглал л байж болох юм гэхэд Витгенштайн дам солигдож байдаг илэрхийллийг алдаатайгаар ойлгох явдалд оршдог “хэлний өвчин” гэж тодорхойлж байна.

Зарим нь философийн томчууд төдийгүй, философи өөрөө бүрмөсөн сөнөлөө, мөхлөө гэх болов. Тухайлбал, философи үхсэн гэж баталдаг М.Фуко үүгээрээ зөвхөн түүний оршин тогтнох академик хэлбэрээс татгалзаж байгаа юм гэж байна. Энэ нь Ниццэгийн гаргасан "Бурхан үхжээ" хэмээх хэллэг нь философийг өөрчлөхтэй, тэгэхдээ түүний агуулгыг биш, харин хэлбэрийг өөрчлөхтэй адил гэдгийг тогтоож өгч байдагтай нэг эрэмбийн юм. Ингэж дүгнэх нь философичид Ахуйн ба Үнэний нэрийн өмнөөс ярих гэж оролддог нь хариуцлагагүй бөгөөд аюултай гэж үздэг П.Фейербанд, Р.Рорти нарын санаа бодолтой бас нийлж байна.

Харин К.О.Апель философийн төгсгөл ирж байна гэдэг сэдвийн эсрэг байр суурьтай. Түүнийхээр бол эцсийн үнэнийг боловсруулан гаргаж байсан "агуу их философчдын" үе өнгөрч байгаа боловч харин өөрийн алдаа онооны тусгал ба онол, практик хоёрын хагарлыг даван туулах арга болсон философи үлдэж байна гэжээ. Ийм тусгалын орчин үеийн хоёр гол хэлбэр бол шүүмжлэлт рационализм (сциентизм) ба герменевтик (сүлд оюуны тухай шинжлэх ухаан) юм гэж тэр үздэг байна.

Философи гэж өнөөдөр юуг хэлж байна вэ? аналитик философи устаж алга болсон уу? метафизикийг хэрхэн даван туулах вэ? гэх мэтийн асуултанд хариу өгч, философи хэрхэн шинэчлэгдэн сэлбэгдэж байгааг коммуникатив үйлдлийн онол дээр тулгуурлан харуулах нь бидний зорилго төдийгүй нийгмийн ажлын философийг монголд судлаж байгааг давхар үзүүлэх бололцоог олгож байна. Энэ зорилгод хүрэх танин мэдэхүйн хамгийн дөт замыг бидний үзэж байгаагаар Ю. Хабермасын коммуникатив үйлдлийн онол гарган өгч чадах юм.

Германы философч, социологч бөгөөд Хоркхаймер, Адорно нарыг залгамжлагч, өнөө үеийн хамгийн нэрт философчдийн нэг гэгдэх болсон Юргэн Хабермас (Habermas) 1929 онд төржээ. Хабермас бол Франкфуртын дэг сургуулийн гэж нэрлэгддэг философичдоос төрж гарсан боловч тэдний шүүмжлэлт онолыг нэлээд зөөлрүүлж, сэтгэцийн шинжилгээний онол ба аналитик философи, орчин үеийн социологи, улс төрийн үзэл санаагаар нэмэн баяжуулж гаргаж ирсэн ёс зүйн философийн шинэ сургаалыг үндэслэгч болжээ.

Хабермас орчин үеийнхний нэгэн адил том философчдын үе нэгэнт ар талд үлдсэн гэдэгтэй санал нэг байна. "Сэтгэлгээний агуу их багш нар муу

нэртэй болжээ" (Моральное сознание и коммуникативное действие. Спб. Наука. 2000. С. 7) гэж тэр дүгнэсэн юм. Гэхдээ "философи мөхсөн" гэдгийг тэрээр хүлээн зөвшөөрдөггүй бөгөөд философи нь өөрөө сэлбэн шинэчлэгдэж, тайлбарлагч ухаан хэвээр үлдсэн гэж үздэг судлаач билээ. Прагматик ба герменевтик философчдын хэлээд байгаа шиг философийн ухаалаг чанар устаж үгүй болоогүй. Ингэж баталдаг улсуудын эсрэг би философи нь шинжлэх ухаануудын орон байрыг зааж өгдөг **заагч, шүүгч** хэмээх нэлээд асуудалтай байр сууринаас зайлуулагдсан хэдий боловч ямар ч байсан түүнээс нэлээд даруухан үүрэг болох **байрыг сэлгээгч, тайлбарлагчийн** үүргийг гүйцэтгэн ухаалаг чанарыг өөртөө авч явж чадах бөгөөд тэгэх ч ёстой гэдэг дүгнэлтэнд тэр хүрсэн юм.

"Философи алга боллоо" гэж шүүмжлэгчдийн хамгийн "сэтгэл татам" жишээ болгож Хабермас эдүгээ Америкийн номер нэг философич хэмээн өргөмжлөгдөж буй Ричард Рортиг авсан юм. Сэтгэлгээний их багш болох Кантын өөрт нь зориулан гаргаж өгсөн юм бүхнийг заадаг ба шүүдэг үүргээ философи нь үнэхээр гүйцэтгэж чаддаг гэдэгт хүмүүсийг эргэлзүүлэхийн тулд Рорти "метафилософийн үндэслэлийг" ашигласан. Үүнтэй нь Хабермас илт маргалгүй чимээгүйхэн хүлээн авсан бололтой. Харин философи нь энэ хоёр үүргээс татгалзахын хамт бас "зүй зохистой байдлыг хадгалагчийн" зорилгоос ухарсан гэдэг дүгнэлт Рорти хийж байгаа нь надад үнэмшил бага санагдаж байна гэж эсэргүүцсэн юм. Рортийнхоор философи сэтгэлгээг өөрийг нь бий болгосон ухаалаг чанарын төлөө тэмүүлэх үүргээсээ философи өөрөө татгалзах ёстой болж байна. Философийн мөхөлтэй хамт бидний жинхэнэ үнэн бөгөөд зайлшгүйн үзэл санаатай холбон үздэг трансцендэнчлэх арга чадвар нь хамтын амьдралын цорын ганц хүмүүний хэлбэрийн зайлшгүй нөхцөл мөн гэдэг итгэл үнэмшил маань бас алга болох ёстой гэнэ. Гэхдээ европын философчдоос прагматизмыг хамгийн өндөр үнэлсэн нь Хабермас гэдгийг бас мартаж болохгүй. Тэр хэлэхдээ, Гегелийн философид гурван бүтээлч хариу урвал гарсан нь Маркс, Кьеркегор ба прагматизм юм гэжээ. Заримдаа түүний коммуникатив үйлдлийн онолыг универсаль прагматикийн үзэл баримтлал гэж нэрлэх нь ч бий.

Философийг академик хэлбэрээр нь аврахын тулд Хабермас диалектик, феноменологи, аналитик философи, герменевтик, үзэл суртлын шүүмж, системийн хандлага, интеракцийн болон перформатив онол, бүр

психоанализийг хүртэл ашиглаж үзсэн юм. Тэгээд эцэст нь ёс зүйг философийн арга болгож хувиргах оролдлого хийсэн бөгөөд түүнийх нь үр дүн болж коммуникатив үйлдлийн онол үүсчээ.

Түүнийхээр философийг үнэн зөвөөр үнэлэхийн тулд хэдийгээр бүрэн хангалтгүй боловч дараах хоёр зүйлийг заавал ялгаж үзэх хэрэгтэй гэнэ. Нэгд, "Бүх юм үзэгдлийн анхдагч бөгөөд бас эцсийн мөн чанарын" тухай ярих ёстой философийн, зөвхөн түүний л гарган өгч чадах дээд үнэн хэмээх оршин байдаг гэх үзэл. Хэрэв ингэж үзвэл, философи нь бүх шинжлэх ухааны хаан, ерөөсөө аливаа амьдрал үйл ажиллагааны үндэслэгээ болж, шинжлэх ухаан ба эрх зүйг үзэхээс өмнө философийг судлах ёстой гэдэг их сургуулийн хумбольдт маягийн загвар зөв болж таарна. Хоёрт, философчдын өөрсдийнх нь амбици (өөрийгөө ихэд бодох) ба тэд үнэн хэрэгтээ ангажментлэгдсэн (тодорхой цаг хугацааг эзэлж) байдаг явдал. Бүр анхны философич нар л хамгийн өндөр нэр хүндтэй индэр болох ахуйн өөрийнх нь нэрийн өмнөөс ярьж, улс гүрнийг удирдахыг санаархаж байсан билээ. Гэхдээ тэд ердийн санаа бодолтой байнга зөрчилддөг, түүний дээр байдаг байсан тул хувийн сонирхол байхгүй, ангажментгүй харагддаг байв. Ямар ч хувийн ашиг сонирхолгүйгээр сэтгэж бас удирдан жолоодох гэдэг нь аль нэгэн бүлэг хүмүүсийн ашиг сонирхол төдийгүй эх орон, түүний уламжлал, заншил ба суртахуунаас ангид хол байх гэсэн үг юм. Философич, төгс төгөлдөр удирдагч хүн нь зөвхөн үзэл санаа ба хуулийн нэрийн өмнөөс хүмүүсийг удирдан жолоодох ёстой. Философийн байр суурь нь ийм байх ёстой гэж Хуссерль үзэж байсан бөгөөд энэ үзэл эрдмийн философийн ертөнцийн их багш нарын олонхийн ухамсарт бат шингэсэн байдгийг хэлэх юун.

Хабермас философийг шүүмжлэх шүүмжлэл гарч байгаа урьдач нөхцлийн хэд хэдэн хэлбэрийг боловсруулан гаргажээ. Тэгэхдээ тэрээр онтологийг биш, харин одоогийн олон философч нар татагдсан хэвээр байгаа трансцендентализмын байр суурийг авч үзсэн юм. Энд үндэслэгээний тухай асуудал танин мэдэхүйн хавтгайд шилжиж, мэдлэгийг үндэслэж өгөх асуудал болон хувирдаг. Хэдийгээр өндөр нэр хүндтэй индэр нь ахуйг биш, харин ухааныг голлох болсон трансценденталь философид репрезентацийн үүрэг, тэгэхлээр ноёрхогч үүрэг нь бас хадгалагдсаар байх болно гэж Хабермас үзжээ. "Шинжлэх ухааны үндэслэгээг үүрд нэг мөсөн тодруулж, туршлагын мэдлэгийн хил хязгаарыг үүрд нэгмөсөн тодорхойлно гэж оролддог тул

философи нь шинжлэх ухаануудад тэдний байрыг зааж өгдөг” гэжээ. Тэгэхдээ практик ухаан ба онолын танин мэдэхүйн оюун дүгнэлтийн арга чадвар хоёрыг хязгаарлан салгах замаар трансценденталь философи нь бүх соёлын хувьд бүхэлд нь шүүгч индэр байхыг оролддог. “Философид шинжлэх ухаануудын байрыг зааж өгөх үүргийг хүлээлгэдэг танин мэдэхүйн фундаменталист онол ба шинжлэх ухаан, ёс зүй ба урлагийн тусгаар тогтносон салбаруудын хувьд ч шударга шүүгчийн эргэлзээтэй үүргийг философи өөртөө авдаг соёлыг бүхэлд нь хамардаг ойлголтын түүхийн биш систем хоёрын хооронд харилцан хэлхээ холбоо байдаг” гэж тэр бичжээ.

Кантын ухааны модернтой фундаментализмыг Гегель шүүмжлэхдээ үндэслэгээний трансценденталь аргын оронд диалектик аргыг гарган тавьсан билээ. Кантын цэвэр эрэгцүүллийн ойлголтууд ердөө л бэлэн байдлаар олдсон болохоос биш үндэслэгдэн гараагүй гэж тэр шүүмжилсэн юм. Тэгээд өөрийн “Сүлд оюуны феноменологи” гэдэг бүтээлдээ эх сурвалжийг (генезис) олж тогтоох замаар энэ дутагдлыг даван туулах оролдлого хийсэн байдаг. Өөртөө байгаа юм субъектийн болж хувирах явц, үргэлж давтагдаж байдаг энэ туршлагыг дахин боловсруулж, өөрчлөн сэлбэхийг тэрээр диалектик гэж нэрлэжээ. Энэ нь улам илүү нарийн бүтцийг, эцсийн эцэст Кантын шинжилсэн ухамсрын бие даасан тэр хэлбэрийг төдийгүй, бүрэн төгс сүлд оюуныг төрүүлэн гаргадаг. Диалектик нь феноменологич Гегельд бэлэн байдлаар нь Кант зөвхөн нээн харуулсан ухамсрын бүтцийн эх сурвалжийг мөрдөн шинжлэх боломж олгосон юм.

Гэхдээ ухамсрын бие биенийгээ ээлж дараалан сольж байдаг хэлбэрийг сэлбэн шинэчлэх нь нэг хэлбэр нь нөгөөгөөсөө үүсэн гардаг имманент зайлшгүй байдлын нотолгоог гарган өгч чадахгүй байна. Диалектикийн энэ дутагдлыг Гегель логикийн хэлбэрт хандсанаар даван туулсан юм. Тэрээр “Логикийн тухай шинжлэх ухаан” гэдэг бүтээлдээ философийн өмнө шинжлэх ухаанд нээгдэн гарсан бүх агуулгыг нэвтэрхий мэдэх аргаар ойлголтонд авчирч оруулах агуу зорилт тавьсан билээ. Тэгснээрээ Гегель философид соёл ба шинжлэх ухааны талаар бүх дэлхийн түүхэн ач холбогдолтой үүргийг оногдуулсан хэрэг.

Харин Гегелийн абсолютизмын, эсвэл Кантын фундаментализмын эсрэг чиглэсэн метафилософийн шүүмжлэл нь бүүр сүүлийн үеийнх бөгөөд тэдний өөрсдийнх нь шүүмжлэлийн мөрөөр явж байна гэж Хабермас

дүгнэжээ. Тэрээр ийм шүүмжлэлийн бие биенийгээ харилцан үр ашигтайгаар нөхөн сэлбэж байдаг хоёр чиг шугам байгааг гарган үзүүлсэн юм.

Хабермасын үзэж байгаагаар капитализмын эдийн засгийн зүй тогтол үйлдвэрлэл ба хуваарилалтын талаар хязгаарлагдмал хэдий ч бололцоо олж авсан төрийн нөлөөгөөр шинэчлэгдэж байгаа ажээ. Улс төрийн хувьд энэ нь төрд оршин байгаа ардчилсан бүтцийн хүрээнд анги, бүлгийн эвлэрэл зөвшилцөлд хүрэх боломж олгодог. Үүний үрээр хямрал зөрчлийн эх сурвалж болон түүнийг шийдвэрлэх арга хэрэгсэл нь эдийн засгийн хүрээнээс удирдлага, засаг захиргааны салбарт шилжих болжээ. Хямрал зөрчлийн шинж чанар ч өөрчлөгдөж одоо нийгэм-соёлын шинжтэй болж байна. Хөдөлмөр үйлдвэрлэлийн рационал байдалд суурилсан удирдлага нийгэмд нэгэнт ноёрхох болсон үйл байдлын бодит сэдэл тэмүүлэлтэй зөрчилд орох боллоо. Нэг талаас, нийгмийн байгууллагажсан бүтэц, нөгөө талаас, нийгэм-соёлын "амьдралын ертөнц" мөргөлдөх болов. Үүнийг даван туулахын тулд Хабермас орчин үеийн шинжлэх ухаан технологийн соёл-иргэншил бүрэлдэн тогтох явцад байгууллагын хэлбэр олж чадаагүй өөр бүтцийг тодорхойлж өгөх учиртай коммуникатив үйлдлийн онолыг санал болгосон юм.

Хүн бүхнийг захиран удирдаж байдаг ёс зүйн болон улс төрийн үүрэг хариуцлагыг хэлний коммуникацийн шинж чанараас ургуулан гаргаж болно гэж тэр үзэж байлаа.

Хабермас хэл шинжлэлийн философид байдаг хэл ярианы үйлдлийн задлан шинжилгээ ба Веберийн гаргасан нийгмийн үйлдлийг үзэл баримтлал болгох санаанд тулгуурлан хүний "бүрэн төгс үйл байдал"-ын хэв маягийг боловсруулж, түүний дотор нь **стратегийн, хэм хэмжээг зохицуулагч ба коммуникатив** гэсэн гурван үйл байдлыг ялган үзжээ.

Стратегийн чиг хандлагатай үйл байдалын зорилго нь харилцан ойлголцох явдал биш, харин "ашиг сонирхлоо хамгаалах" явдал байдаг бөгөөд энэ нь хамтран ажиллагчийгаа санаатайгаар юм уу эсвэл санамсаргүйгээр хууран мэхлэхэд хүргэдэг. Эхний тохиолдолд манипуляцийн тогтолцоо бүрэлдэх ба хоёрдахь нь коммуникацийг байнга гажуудуулдаг байна. Хэрвээ хүмүүс өөрийн үйл байдлын дан ганц үр дүн, амжилтыг гол чиг баримжаа болгоод байх юм бол эргэн тойрныхоо хүмүүст эдийн засгийн талаар юм уу, эсвэл ямар нэгэн өөр арга замаар даралт шахалт үзүүлж эхэлдэг. Ийм стратегийн үйл байдал нь хүрээлэн буй орчны өгөгдсөн нөхцөл

байдлаас болоод амьдрахын тулд гадаад ертөнц ба бусад хүмүүсийн эсэргүүцлийг даван туулж өөрийн ашиг сонирхлоо хүчээр хэрэгжүүлэх гэсэн хувь хүний эрмэлзлэлээс үүсэн гардаг. Үйл байдлын энэ хэв маягийн үед нэг хүч нь нөгөө хүчээр тодорхойлогдож, бас хязгаарлагдаж байдаг. Энд хүч л үйлчилдэг болохоос үнэн ба шударга ёсны аль аль нь байхгүй юм. Эдний аль алиных нь нийгэм, соёл ба хувь хүнд үзүүлэх үр дагавар үйлийн үргүй алдаа байдаг. Тухайлбал, нийгмийн интеграцичлалын хүрээнд хүнийсэх явдал, аноми үүсч хамт олонтой ижилдэх үйл алдагддаг. Соёлын хүрээнд амьдралын утга учир ба чиг баримжаа бүдгэрч, засаглалын бүтцийн хүлээн зөвшөөрөгдсөн чанар алдагдахад хүрдэг. Хувь хүний хүрээнд уламжлал мартагдаж, сэдэл тэмүүллийн иж бүрдэл зөрчигдэж, янз бүрийн сэтгэцийн гажиг үүсдэг. Энд хүч ба шударга ёсыг хослуулж болох эсэх тухай мөнхийн асуулт гарч ирэх болно. Хүчийг үнэн ба шударга ёстой хамтруулан хэргжүүлж болох газар нь хэлэлцээний явцад санал бодол ба түүнийхээ үндэслэлийг солилцож, бие биенийгээ харилцан ойлголцож, хүлээн зөвшөөрч, зөвшилцөлд хүрэх явдалд зориулагдсан коммуникатив үйл байдал мөн.

Коммуникатив үйл байдал буюу харилцан ойлголцсон хамтын үйл ажиллагааг чиг баримжаа болгосон үйл байдлын хувьд бүх юм дээрхийн эсрэг эргэж, дэг журам ба хэм хэмжээнд захирагдсан орчин, хүмүүсийн хоорондын хүлээн зөвшөөрөлцсөн тогтвортой харилцаа үүсч цааш гүнзгийрэн хөгжих, өөрөө бие даан хэрэгжих боломж бүрддэг. Хабермасын бодож байгаагаар, стратеги үйл байдлыг ялган шинжлэх нь, нийгмийг интеграцчлах баталгааны доор системийн зүгээс гарах нуугдмал хүчирхийллийг олж илрүүлэх боломж олгодог байна. Харин жинхэнэ интеграци нь коммуникатив ойлголцлын буюу харилцан ойлголцсон хамтын ажиллагааны замаар л бий болж чадах ажээ.

Хабермасын байр суурь нь шүүмжлэлт үзэл, феноменологи, херменевтик ба аналитик философийн уламжлалыг нэгтгэн хэрэглэсэн төдийгүй өөрчлөгдөн хувирч байдаг маягтай тул нэг утгаар шууд тодорхойлон хэлэхэд бэрхтэй. Оюуныхаа өөрчлөлт хувьслын явцад тэрээр ёс суртахууныг зайлшгүй мөртлөө ашиг тусгүй сургаал номлолоос болиулж, бид бүхний практик ба хэл ярианы үйлдлийг жинхэнэ зохицуулагч болгон хувиргах асуудлыг шийдвэрлэхээр зүтгэсэн юм.

Зөвхөн суурь үндсэнд нь хандаж байж шийдвэрлэж болох асуудлыг когнитив арга хэрэгслийн хүрээнд хэт татан оруулж үздэг орчин үеийн өвөрмөц нэг талыг барьсан хандлагыг давахын тулд бид арга хэрэгслийн ухааныг шүүмжлэх явдлыг бас авч үзэх ёстой болж байна. "Би юу хийх ёстой вэ?" гэх маягийн ёс зүйн практик асуултанд зүй зохистой зорилгын хүрээнд хариу өгөхөд түвэгтэй учир ухаалаг хэлэлцэх явдлын хүрээний гадна ямагт үлдэж байдаг. Орчин үеийн ухамсрын энэ эмгэгийг нийгмийн ёс зүйн философи буюу Хабермасын хэлснээр "нийгмийн онолын хүрээнд" шийдэгдэх ёстой гэдгийг бид энд иш үндэс болгож байна.¹

"Эмпирик онол нь өөрийн хэрэглэж байгаа хэм хэмжээний онолын ач холбогдолтой гэдгийг урьдчилан мэдэж байдаг. Харин эмпирик онолд хэрэглэгдэж байгаа философийн реконструкци нь хуучирч тэнцэхээ болимогц тухайн хэм хэмжээний онол үр ашигтай гэдэг нь тэр дороо эргэлзээтэй болдог байна. Хэм хэмжээний онолыг хэрэглэх нь судалгааны герменевтик хэмжилд бас нөлөөлдөг. Өгөгдүүн нь ерийн тайлбарыг биш, харин "онолыг илүү их удирдлага болгодог"² байна гэж тэр бичжээ. Тийм учраас Хабермасын онолыг зүй зохистой чанарын (рациональность) коммуникатив баримтлал гэж нэрлэж бас болно.

Даяаршлын нөлөөгөөр хүмүүс бие биетэйгээ улам ойртон нягтарч, хэн нэгэн нь бусдыгаа дарангуйлагч үйл байдлаас харилцан ойлголцсон хамтран ажиллах үйл байдал руу улам бүр шилжсээр байгаа үед нэгэн төрөлхтний "хувь чанар" ба "нийгмийн" утга агуулгын нэгдэлийн мөн чанар нь **уламжлал** ба **сүлд оюун** хоёроор нь тодорхойлогдох ёстой. Чухам үүнийг үндэс болгон бид нийгмийн ёс зүйн өөрчлөлт, хөгжлийн хүмүүнлэг хандлага коммуникатив үйл ажиллагаанд зайлшгүй түшиглэхэд хүргэж, тэр нь хүй хамтлагын хүрээнд тод илэрч байна гэж үзэхэд хүрсэн. Ерөөс Кантын уламжлалаар хөгжиж байгаа бүх когнитив ёс зүйд зан суртахууны тодорхойлолтыг "хувь чанар" ба "нийгмийн" хоёр талыг тооцон үзэж байж тодруулан гаргадаг билээ. Когнитивизм, универсализм ба формализмын нийтлэг үндсийг дискурсийн этикийн арга хэрэгслээр үндэслэсэн ёс зүйн зарчмаар хангаж болно гэж Юргэн Хабермас үзсэн юм. Тийм зарчмыг тэрээр дараах маягаар томъёолжээ. "Бодит хэм хэмжээ бүр нь түүнийг **нийтээр** даган биелүүлэх нь

¹ Jürgen Habermas. *Moralbewusstsein und kommunikatives Handeln*. Suhrkamp Verlag Frankfurt am Main, 1983. X, 71

² Юрген Хабермас. Моральное сознание и коммуникативное действие. С.-П., 2000, с. 64

хувь хүн бүрийн ашиг сонирхлыг хангах явдалд үндэслэсэн шууд ба дагалдах үйлдлийг түүнд хүртээлтэй *бүх хүн* ямар ч албадлага шахалтгүй хүлээн авч байгаа үед л үр ашгаа өгч чадах болно”³ гэж тэр бичсэн байна.

Дискурсын ёс зүйн энэхүү үндсэн зарчим нь *когнитивизм, универсализм ба формализм* гэсэн гурван гол шалгуурыг өөртөө агуулж байна гэж үзэж болох юм.

Эхнийх нь, ёс зүйн практикийн асуудал нь зүй зохистой ухаалаг үндэслэгээ ба хэлэлцүүлгийн тусламжтайгаар шийдвэрлэгдэж болох бөгөөд энэ явцад хүмүүс ёс зүйн зөв ба буруу дүгнэлтүүдийг ялган ойлгох боломжтой болно гэж үздэг. Энэ зарчим нь менталитет юм уу, эсвэл нутаг дэвсгэр, салбарын шинжээр нэгдсэн хүмүүсийн бүлгийн хүрээнд хэрэгжих боломжоор илүү байна. Хүмүүсийн ийм нэгдлийг судлан шинжлэх онолын ажилд тохиолддог нэг бэрхшээл бол уг ойлголтыг янз бүрээр тайлбарлан нэрлэж байгаа явдал мөн. Английн “community action” гэдэг үг нь “нийгэмлэгийн ажил”, “хүй хамтлагийн ажил хэрэг” ч юм уу, ерөөс “хамтралын үйл хэрэг” гэсэн утгатай, үүнийг орос хэлэнд “община”, эсвэл “сообщество” гэдэг үгээр оноож орчуулсан байдаг. Энэ хэллэгийн философийн тодорхой утга нь “хүй хамтлагт тулгуурласан ажил” буюу “харилцан ойлголцож хамтран ажиллах” гэсэн санаатай дүйх юм. Ийм хамтлагт явагддаг нийгэм, халамжийн ажлыг манай нийгмийн ажлын ном зохиолд “нийгэм хамт олонд түшиглэсэн халамжийн ажил” гэдэг ойлголтоор анх хэрэглээд тэр нь нэгэнт хэвшил болжээ. Түүнээс гадна, хүмүүсийн ийм хүй хамтлаг нь хүн, мод, чулуу гэх мэтийн нэг адил тодорхой хэмжээ дамжаатай бодитой оршиж байдаг зүйл биш юм. Ийм хүй хамтлаг нь түгээмэл нийтлэг шинж чанар, жам ёсны салшгүй зааг хязгаартай байдаггүй нь ойлгомжтой. Тэгэхлээр “хүй хамтлаг” гэдгийг нийгмийн ямар нэгэн хамтлаг бүрэлдүүнд судлаачдын өгсөн тодорхойлолт, оюун ухааны бүтээмж гэж ойлгох нь илүү зүйд нийцэх биз. Үүнээс үндэслэн нийгмийн ажлын онолын судалгаанд ийм маягийн хүй нэгдлийг *соёлын өргөн хэлхээ холбоогоор холбогдсон хүмүүсийн ёс зүйн хамтлаг* гэж авч үзэх нь илүү танин мэдэхүйн болон практик ач холбогдолтой гэсэн саналыг дэвшүүлж байна. Хамтын үйл ажиллагааны ёс зүйн ухамсрыг анх шинжлэх ухааны эргэлтэнд оруулсан Юргэн Хабермас “өдөр тутмын хамтын ажиллагааны практикт когнитив тайлбарлал, ёс зүйн

³ Юрген Хабермас. Моральное сознание и коммуникативное действие. С.-П., 2000. С. 179

хүлээлт, илрэл ба үнэлгээ нь бие биетэйгээ хамгийн их холбогдон сүлэлдсэн байдаг. Тийм учраас амьдралын ертөнцөд явагдаж байдаг харилцаа ба харилцан ойлгох үйл явцад зөвхөн шинжлэх ухаан ба техникийн сайшаалтай үр жимс төдийгүй мөн соёлын уламжлал хамгийн эргэн их хэрэгтэй байдаг”¹ гэж онцлон тэмдэглэсэн юм. Хүмүүсийн ийм хамтлаг нь бас ч өөр өөрийн гэсэн онцлох шинжтэй, хэмжээ үзүүлэлттэй бөгөөд түүнийг нь, юуны өмнө соёлынх нь харилцааг философийн судалгаанд харгалзан үзэх ёстой юм.

Хамгийн шилдэг коммуникатив нийгэмд бол “сүлд оюуны нэгдэл нь түүний дуу хоолойн олон янз байдалд оршино”. Постмодернизм нэгдмэл нэг ертөнц нь олон янзын санал бодлын цэцэрлэг болж оршдог гэдэг. Хабермас аж үйлдвэржсэний дараах ёс зүй, үндэстний дээр байх ёс зүйн тухай үзэл санааг дэвшүүлсэн. Харин би бол ёс зүйг ингэж их түгээмэл үндэслэх талын хүн биш. Би соёлын ялгаатай байдал ёс зүйд хамаатай гэж үздэг юм.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Jurgen Habermas. Moralbewusstsein und kommunikatives handeln. Suhrkamp Verlag Frankfurt am Main. 1983.
2. Юрген Хабермас. Моральное сознание и коммуникативное действие. С-П., 2000

¹ Юрген Хабермас. Моральное сознание и коммуникативное действие. Санкт-Петербург. 2000.с. 31-32.